



2024.08.28

Уг барилга нь 10x10 метр харьцаатай шугаман суурьтай, модон ханатай эрдэс хөвөн дулаалгатай, шувуу нуруу дээвэртэй нэг давхар байна. Дотроо 3x4 хэмжээтэй нэг ажлын өрөөтэй байна. Бусад хэсэг нь хурлын заал байна.

Буурь: Шинээр баригдах багийн төвийн барилгын суурь, шалан доорхи ургамлын үе овойлдог хөрсийг бүрэн зайлцуулна. Барилгын суурийн нүхийг ухаж суурийн ажлыг хийх явцад суурийн нүхэнд борооны болон газрын гадаргуун ус орорхоос хамгаалах хэрэгтэй. Шалан доор болон суурийн хажуугаар буцааж чигчих хөрс нь овойлт суулт үүсэхгүй элсэн чигжээс /элсний эзлэх хувь 30 хувиас багагүй/-тэй хайрган хөрс байна.

Суурь: Барилгын суурийг шугам суурь байхаар төлөвлөв. Суурийн бетоны анги B15. Шугаман суурийн доор 100 мм-ийн зузаантай B10 ангийн бетоноор бетон бэлтгэл хийж өгнө. Суурийн ус тусгаарлагчийг заавал 2 үе түрхэнэ.

Хана хамар хана: Барилгын гадна 100*150 мм палкен ханатай зураг төслийн дагуу модон рам бэхлэж, 50 мм зузаантай эрдэс хөвөн дулаалга салхи битүүмжлэх материалын хамт хийж 50 мм агаарын үе гарган 50*50 мм бурс modoор дарж хадна. Гадна өнгөлгөөний төмөр сайданг хавтангаар өнгөлж заслын ажлыг гүйцэтгэнэ. Салхи битүүмжлэгчийг ханын босоо чиглэлийн дагуу ам зөрүүлж хийнэ.

Хаалга, цонх: Цонх цагаан өнгийн хуванцар рамтай тунгалаг өнгийн давхар шилтэй вакум цонх байна. Цонхыг суулгахдаа цанталтын үеийг өнгөрөөж суулгана. Хаалга цонх нь Монгол улсад мөрдөж буй норм стандарт MNS 5830-2007 дулаан техникийн шаардлагыг хангасан байна. Хаалга нь норм стандартад нийцсэн төмөр бүргэд хаалга байна. 5 ширхэг цонхтой байна. Урагшаа харсан 3 цонхтой, дээшээ харсан 1 цонхтой, доошоо харсан 1 цонхтой байна.

Дээвэр: А нуруу буюу шувуу нурууг 50*150 мм банаар холбоос бэхэлгээг сайтар хийж зангидана. Модон хучилтны дээр уур ус тусгаарлагч болон 50 мм зузаан эрдэс хөвөн дулаалга хийнэ. Шувуу нурууг хийсний дараа 25 мм-н зузаан банаар нурууг хучиж долгионт төмрөөр дээвэрлэнэ.

Дотор засал: Таазыг 60*60 хэмжээтэй лампир угсарна. Дотор ханыг рам зангидах гипсэн хавтангаар өнгөлөж 2 үе замаскан тэгшилгээ хийж тосон будгаар будна.

Шал халаалт: шалыг нь дулаалгатай паркетан шал байна. Халаалтыг Герман Silvercrest брендийн 25 м² халаах хүчин чадалтай, агаар хуурайшуулахгүй галын аюулгүй үед автоматаар унтрах гээд удирдахад маш энгийн хэрнээ ухаалаг болсон Silvercrest цахилгаан халаагуур шийдэж өгнө.

Цахилгаан хангамж: Цахилгааны тэжээлийг өөрийн эх үүсвэртэй байх ба автоматтай хувиарлах самбарыг хананд ил байрлуулахаар төлөвлөх. Самбараудын тэжээлийн шугаманд ПВ утсыг пластмассан хоолойд ил тавина. Гэрэлтүүлэгчүүдийг ерөнхий ба ажлын байрны гэрэлтүүлгийн зориулалтаар төлөвлөх. Ерөнхий гэрэлтүүлэгт улайсах ба люминесцент чийдэнтэй гэрэлтүүлэгч тавина. Ердийн нөхцөлтэй өрөөнд гэрэлтүүлгийн шугаманд ПВ маркийн утсыг тааз хананд далдлагчанд сувлэн ил тавина. Өрөөнд газардуулгын сэрээтэй олон янзын сэрээтэй холбох боломжтой розеткыг хананд ил тоноглоно. Цахилгааны ерөнхий самбараас хуваарилах самбар хэрэглэгч розетка хүртэл нэмэлт газардуулагын утсыг татаж газардуулга хийнэ.

Үүдний тампар: улаан тоосгоор 1,5*2 метр хэмжээтэй барина.

Бусад тавигдах шаардлага: Зураг төсөлд барилга угсралтын ажлыг дулааны улиралд гүйцэтгэхээр тусгасан бөгөөд хэрэв хүйтний улиралд гүйцэтгэхээр болвол холбогдох норм, дүрэм заалтыг мөрдлөгө болгон ажиллах шаардлагатай. Барилгын гадна ханыг 15-ын палкаар өрж, зураг төслийн дагуу модон рамаар бэхэлж 50 мм зузаантай дулаалга хийнэ.

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Б.ЧИНБАТ
БОЛОВСРУУЛСАН
ЖАРГАЛАНТ БАГИЙН ЗАСАГ ДАРГА Д.СҮХ-ОЧИР